

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
	3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал	11
	3.2 Бараа материал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
5	Хавсралт.....	21
	5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С. МАГНАЙСҮРЭН ТАНАА

2019.02.25 № 06/295
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Барилга хот байгуулалтын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн батлагдсан төсөв, гүйцэтгэл, бараа материалтай холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Энхжин хариуцаж хэрэгжүүлэв.

Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/269 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Барилга, хот байгуулалтын яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын норм, нормативын баримт бичгийн тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн үр дүнг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Инженерийн дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах; /ЗГ-ын 2016 оны 220-р тогтоолоор нэмсэн/
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Нийтийн аж ахуй, орон сууцны салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, тус яамны чиг үүрэгтэй холбогдон гарсан шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах;

Барилга, хот байгуулалтын яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Барилга, хот байгуулалтын яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Барилгын тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Газрын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Барилга, хот байгуулалтын яам нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа тул санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам,

зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Барилга, хот байгуулалтын яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Барилга, хот байгуулалтын яамны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous 3.0” програм хангамж ашигладаг байна.

Барилга, хот байгуулалтын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Барилга, хот байгуулалтын яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын суурийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэнтэй холбоотой.

Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны нийт зардал 2,034,331.5 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 40,686.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг төлөвлөлтийн шатанд тогтоосон 2 хувийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт 74,948.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан болно. Үүнд:

- Тендерийн үйл ажиллагааны орлого, зардлыг санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүйгээс тайлант үеийн орлого зардлыг 64,338.3 мянган төгрөгөөр буруу илэрхийлсэн,
- Санхүүгийн тайланд 5,260.4 мянган төгрөгийн өглөгийг тусгаагүй,
- Төсвийн гүйцэтгэлийг тайлагнахдаа санхүүжилтийн эх үүсвэрийг 5,350.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан зэрэг зөрчлийг аудитын явцад залруулсан болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	5,963.2	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1,017.1	
3	Албан шаардлага өгсөн	1	14,565.0	
	Дүн	4	21,545.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал

Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн нь 2018 оны 04 дүгээр сарны 16-ны өдрөөс Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаатай холбогдуулан үндсэн цалингийн 40 хувиар тооцож түр орлон гүйцэтгэх хугацааны

урамшууллыг олгож байсан бөгөөд 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс дээрх албан тушаалд томилогдон ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан хаагчийг түр орлон гүйцэтгэх хугацаа 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөр дуусгавар болсон боловч үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгох урамшууллыг нийт 1,017.1 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2.8.1.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөвт байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлаас 14,565.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар гүйцээж мөшгин шалгаж, тулган баталгаажуулаагүй ажил гүйлгээ байхгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Барилга, хот байгуулалтын яамны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 8 арга хэмжээнд зориулан 2018 онд 1,661,365.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,656,015.0 мянган төгрөг буюу 99.7 хувьтай ажиллаж, 5,350.2 мянган төгрөгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг Улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Барилга, хот байгуулалтын яам нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь shilendans.gov.mn цахим хуудсанд батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллүүд, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, бусад цэсэд байрлуулсан мэдээллийг оруулж байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 80 хувьтай байгаа нь “Санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллах” гэсэн зөвлөмж хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Барилга, хот байгуулалтын яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд нийт 3,400.0 мянган төгрөгийн зориулалт бус зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Урсгал засварын зардалд 900.0 мянган төгрөг, зар сурталчилгааны зардалд 2,500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь үнэн зөв байдал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.2-т "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.2-т "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Төсвийн захирагчид асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

3.2 Бараа материал

3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалын данснаас нийт 2,563.2 мянган төгрөгийн хөрөнгийг анхан шатны баримт бүрдэлгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

3.2.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу

Төсвийн захирагчид асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,453,007.80	65,585,764.66
33	АВЛАГА	2,709,880.00	11,695,045.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	853,095.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	10,841,950.00
335	Бусад авлага	2,709,880.00	-
34	УРЬДЧИЛГАА	16,000,000.00	25,308,547.66
34600	Урьдчилж гарсан зардал	16,000,000.00	25,308,547.66
35	БАРАА МАТЕРИАЛ	26,743,127.80	28,582,172.00
354	Хангамжийн материал	26,743,127.80	28,582,172.00
35410	Бичиг хэргийн материал	5,738,475.00	5,703,875.00
35420	Аж ахуйн материал	1,598,035.80	1,494,640.00
35430	Сэлбэг хэрэгсэл	165,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	37,180.00	-
35460	Хүнсний материал	422,050.00	-
35470	Бусад хангамжийн материал	18,782,387.00	21,383,657.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	165,163,417.68	1,130,515,549.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	165,163,417.68	1,130,515,549.02
392	Биет хөрөнгө	163,003,417.68	1,114,742,977.69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	376,355,798.00	403,855,798.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(298,979,131.40)	(366,204,696.20)
39205	Машин тоног төхөөрөмж	310,488,355.26	2,461,005,027.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(282,298,252.84)	(1,433,879,932.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	254,443,764.66	230,661,820.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	(197,012,894.04)	(180,695,039.29)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,287,475.00	4,962,075.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,281,696.96)	(4,962,075.00)
393	Биет бус хөрөнгө	2,160,000.00	15,772,571.33
39301	Програм хангамж	14,880,810.00	14,880,810.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(12,720,810.00)	(14,880,810.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,500,000.00	25,100,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(4,500,000.00)	(9,328,228.67)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	210,616,425.48	1,196,101,313.68
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	5,371,370.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5,371,370.75
413	Өглөг	-	5,371,370.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	110,910.75
4136	Бусад өглөг	-	5,260,460.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	5,260,460.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	210,616,425.48	1,190,729,942.93
51	Засгийн газрын хувь оролцоо	210,616,425.48	1,190,729,942.93
51101	Өмч: - төрийн	324,390,884.93	324,390,884.93
512	Хуримтлагдсан үр дүн	(113,774,459.45)	866,339,058.00
51210	Өмнөх үеийн үр дүн	(113,774,459.45)	(113,774,459.45)
51220	Тайлант үеийн үр дүн	-	980,113,517.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	210,616,425.48	1,196,101,313.68

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,636,804,074.42	3,014,445,008.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,568,474.42	1,303,587,248.39
120	Нийтлэг татварын бус орлого	39,568,474.42	1,303,587,248.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,205,386.22	1,239,248,919.07
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,205,386.22	1,239,248,919.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,597,235,600.00	1,710,857,759.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,597,235,600.00	1,661,365,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,597,235,600.00	1,661,365,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	49,084,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	49,084,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	407,259.91
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	407,259.91
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,993,091,254.17	2,026,566,789.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,842,576,048.25	1,927,163,058.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,842,576,048.25	1,927,163,058.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,047,744,204.24	1,036,350,521.00
210101	Үндсэн цалин	1,041,148,134.24	1,036,350,521.00
210102	Нэмэгдэл	5,000,000.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	1,596,070.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,412,756.85	125,886,577.00
210201	Тэтгэврийн даатгал	75,545,661.85	84,680,643.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,688,306.00	10,501,526.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,272,006.00	8,422,976.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,082,435.00	2,025,585.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,824,348.00	20,255,847.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,744,000.00	14,392,230.00
210304	Байрны түрээс	21,744,000.00	14,392,230.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98,844,582.00	104,297,820.52
210401	Бичиг хэрэг	47,385,648.48	53,093,596.00
210402	Тээвэр, шатахуун	18,717,490.00	17,232,314.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,287,793.52	13,857,916.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,413,650.00	20,113,993.80
210408	Бараа материал акталсны зардал	40,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,396,520.00	4,921,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,927,840.00	-
210604	Урсгал засвар	6,468,680.00	4,921,850.00
2107	Томилот, зочны зардал	17,285,520.00	26,416,576.00
210702	Дотоод албан томилот	17,285,520.00	26,416,576.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	408,365,952.40	312,646,198.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,091,212.40	304,540,048.32
210803	Даатгалын үйлчилгээ	3,362,720.00	4,229,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	645,800.00	586,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	124,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,222,220.00	3,166,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	118,782,512.76	302,251,285.95

Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,083,897.08	11,143,480.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,698,615.68	291,107,805.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,443,065.92	99,403,730.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	140,974,379.00	94,053,517.98
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	94,932,179.00	27,644,057.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,542,200.00	46,809,460.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,500,000.00	19,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,468,686.92	5,350,212.30
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,468,686.92	5,350,212.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,072,140.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,072,140.00	-
222001	Тоног төхөөрөмж	5,072,140.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(356,287,179.75)	987,878,219.23
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,217,724.91	7,764,701.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	25,216,767.91	7,764,701.78
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	957.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(25,217,724.91)	(7,764,701.78)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(381,504,904.66)	980,113,517.45

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,597,235,600.00	1,774,788,829.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	64,338,329.32
120	Нийтлэг татварын бус орлого	-	64,338,329.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,597,235,600.00	1,710,450,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,597,235,600.00	1,661,365,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,597,235,600.00	1,661,365,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	49,084,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	49,084,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,596,499,610.00	1,760,223,829.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,596,499,610.00	1,760,223,829.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,448,863,544.08	1,646,688,609.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,038,560,100.00	1,026,940,800.00
210101	Үндсэн цалин	647,506,200.00	608,490,000.00
210102	Нэмэгдэл	267,015,100.00	367,032,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,418,200.00	51,418,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	72,620,600.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,241,400.00	123,248,500.00
210201	Тэтгэврийн даатгал	114,241,400.00	82,171,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	10,269,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	8,215,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,053,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	20,538,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,750,000.00	18,210,000.00
210304	Байрны түрээс	24,750,000.00	18,210,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,708,810.00	85,097,396.72
210401	Бичиг хэрэг	18,504,196.48	37,401,966.00
210402	Тээвэр, шатахуун	18,918,170.00	17,232,314.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,834,783.52	13,857,716.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,451,660.00	16,605,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,950,000.00	4,921,900.00
210604	Урсгал засвар	4,950,000.00	4,921,900.00
2107	Томилолт, зочны зардал	18,807,400.00	23,706,696.00
210702	Дотоод албан томилолт	18,807,400.00	23,706,696.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	151,222,609.00	327,811,398.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142,220,089.00	318,479,048.32
210803	Даатгалын үйлчилгээ	3,362,720.00	4,229,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	645,800.00	586,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,950,000.00	4,417,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,623,225.08	36,751,918.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,623,225.08	36,751,918.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,636,065.92	113,535,220.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,167,379.00	97,343,057.98

Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	97,125,179.00	36,194,057.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,542,200.00	41,549,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,500,000.00	19,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,468,686.92	16,192,162.30
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,468,686.92	5,350,212.30
213304	Хөрөнгийн	-	10,841,950.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>735,990.00</u>	<u>14,565,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	735,990.00	14,565,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	735,990.00	14,565,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	735,990.00	14,565,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	735,990.00	14,565,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(735,990.00)</u>	<u>(14,565,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	324,390,884.93		261,763,805.15	586,154,690.08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		5,966,640.06	5,966,640.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93		267,730,445.21	592,121,330.14
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-		-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-		-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
Тайлант үеийн үр дүн	-		(381,504,904.66)	(381,504,904.66)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93		(113,774,459.45)	210,616,425.48
2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	324,390,884.93		(113,774,459.45)	210,616,425.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93		(113,774,459.45)	210,616,425.48
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-		-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-		-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-		-	-
Тайлант үеийн үр дүн	-		980,113,517.45	980,113,517.45
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93		866,339,058.00	1,190,729,942.93

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,661,365,700.00	1,656,015,487.70	5,350,212.30	99.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,661,365,700.00	1,656,015,487.70	5,350,212.30	99.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,563,466,700.00	1,558,672,429.72	4,794,270.28	99.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,026,940,800.00	1,026,940,800.00	-	100.00
210101	Үндсэн цалин	608,490,000.00	608,490,000.00	-	100.00
210102	Нэмэгдэл	367,032,600.00	367,032,600.00	-	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,418,200.00	51,418,200.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,248,500.00	123,248,500.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	82,171,100.00	82,171,100.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,269,400.00	10,269,400.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,215,400.00	8,215,400.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,053,800.00	2,053,800.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,538,800.00	20,538,800.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,210,000.00	18,210,000.00	-	100.00
210304	Байрны түрээс	18,210,000.00	18,210,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,777,500.00	66,297,596.72	479,903.28	99.28
210401	Бичиг хэрэг	19,017,400.00	18,602,166.00	415,234.00	97.82
210402	Тээвэр, шатахуун	16,449,900.00	17,232,314.00	(782,414.00)	104.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,000,000.00	13,857,716.72	1,142,283.28	92.38
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,310,200.00	16,605,400.00	(295,200.00)	101.81
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,950,000.00	4,921,900.00	28,100.00	99.43
210604	Урсгал засвар	4,950,000.00	4,921,900.00	28,100.00	99.43
2107	Томиллолт, зочны зардал	23,807,400.00	23,706,696.00	100,704.00	99.58
210702	Дотоод албан томиллолт	23,807,400.00	23,706,696.00	100,704.00	99.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	267,270,800.00	263,085,419.00	4,185,381.00	98.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	253,844,500.00	253,753,069.00	91,431.00	99.96
210803	Даатгалын үйлчилгээ	7,664,500.00	4,229,550.00	3,434,950.00	55.18
210804	Тээврийн хэрэгслийн татвар	712,800.00	586,600.00	126,200.00	82.30
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,950,000.00	4,417,200.00	532,800.00	89.24

Барилга, хот байгуулалтын яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32261700.00	32261518.00	182.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,261,700.00	32,261,518.00	182.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97899000.00	97343057.98	555,942.02	99.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,899,000.00	97,343,057.98	555,942.02	99.43
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	36,250,000.00	36,194,057.98	55,942.02	99.85
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,549,000.00	41,549,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,100,000.00	19,600,000.00	500,000.00	97.51
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,661,365,700.00	1,656,015,487.70	5,350,212.30	99.68
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,661,365,700.00	1,656,015,487.70	5,350,212.30	99.68
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,661,365,700.00	1,656,015,487.70	5,350,212.30	99.68
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	80	73	7	91.25
620001	Удирдах ажилтан	13	13	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	60	53	7	88.33
620003	Үйлчлэх ажилтан	7	7	0	100.00

5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/308/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Барилга, хот байгуулалтын яам			Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Төрийн захиргаа удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн нь 2018 оны 04 дүгээр сарны 16-ны өдрөөс Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаатай холбогдуулан үндсэн цалингийн 40 хувиар тооцож түр орлон гүйцэтгэх хугацааны урамшууллыг олгож байсан бөгөөд 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс дээрх албан тушаалд томилогдон ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан хаагчийг түр орлон гүйцэтгэх хугацаа 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөр дуусгавар болсон боловч үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгох урамшууллыг нийт 1,017.1 мянган төгрөгөөр илүү олгосон байна.	1,017.1	Төлбөрийн акт тогтоох	Төрийн нарийн бичгийн дарга	С.Магнайсүрэн
				Нягтлан бодогч	П.Дэлгэрмаа
2	Төсөвт байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлаас 14,565.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.	14,565.0	Албан шаардлага өгөх	Төрийн нарийн бичгийн дарга	С.Магнайсүрэн
				Нягтлан бодогч	П.Дэлгэрмаа
3	Тайлант онд нийт 3,400.0 мянган төгрөгийн зориулалт бус зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Урсгал засварын зардалд 900.0 мянган төгрөг, зар сурталчилгааны зардалд 2,500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	3,400.0	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга	С.Магнайсүрэн
				Нягтлан бодогч	П.Дэлгэрмаа
4	Бараа материалын данснаас нийт 2,563.2 мянган төгрөгийн хөрөнгийг анхан шатны баримт бүрдэлгүйгээр зарцуулсан байна.	2,563.2	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга	С.Магнайсүрэн
				Нягтлан бодогч	П.Дэлгэрмаа
Нийт дүн		21,545.3			

